# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр<br>
Тендер шалгаруулалтын нэр: **Гидро экскаватор**<br>
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202008552**

***“Монголросцветмет” ТӨҮГ*** эрх бүхий тендерт оролцогчдоос ***“Гидро экскаватор”*** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг*)* бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн ***30*** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 оны жилийн эцсийн тайлан.
- Аудитын тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 он.
- Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Туршлага: 2018, 2019 онд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт, эсхүл гэрээ дүгнэсэн актын хамт. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2 жилээс багагүй (2018, 2019).

Тендерийн хамт ***55 000 000 /тавин таван сая/*** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх**: Зөвшөөрнө.**<br>
Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Хаяг: Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, 405 тоот өрөө, утас: 450060 + 118

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**